



НЬЮ ЖУУЛЧИН ТУРС
ДЭХИГТЭЭР АВАХ ТАНИ МӨРӨӨДӨРГТ БИД ШИЛЭГДЭНЭ

БАЛИ АРАЛ

Ерөнхий мэдээлэл

Улс: Индонези

Чиглэл: Бали

Хугацаа: 5 шөнө, 4 өдөр

Эхлэх өдөр: 2020-11-19 - 2020-11-23

Код: Bali

Үзэх зүйлс

Үнэ

Сонголт 1 - Том хүн: **1,350,000₮**

Аяллын хөтөлбөр

Өдөр 1. Улаанбаатар - Хонг Конг/Инчеон - Бали

Энэ өдөр дамжин нислэгээр Бали арал руу ниснэ. Ингээд орой нь ирж, зочид буудалдаа байрлан амарна.

Өдөр 2. Бали

Өглөөний цайны дараа Tanah Lot буюу **Далайн ариун сүмээр** зочилно. Бали арлын далай эрэг дахь хамгийн гайхалтай газрын нэг бөгөөд 16-р зуунд далайн эргийн аварга том хадан хавцал дээр баригдсан. Далайн давалгаан түрлэгт хадан хавцал нь дугуй тойрог хэлбэртэй болсон. Дараа нь **Үлүвату** хэмээх хадан хясаа буюу **Хайрын хясааг** үзэж сонирхоно. Оройн хоолны дараа буудалдаа хүргүүлэн амарна.

Өдөр 3. Бали

Өглөөний цайны дараа Кутагийн төвд байрладаг дэлхийд 3-т, Азидаа 1-т ордог **Waterbom усан парк**-т өдөржин тоглоно. Уг парк нь Индонезийн хамгийн том цэвэр усны шүүн гаргадаг технологитой парк бөгөөд олон нэр төрлийн усан тоглоомон дээр тоглож, зугаацах юм. Ингээд орой нь зочид буудалд байрлан амарна.

Өдөр 4. Бали

Өглөөний цайгаа зочид буудалдаа уусны дараа **Алт Мөнгөн эдлэлийн музей**, үзэж сонирхоно. Мөн **Батик торго даавууны дэлгүүр** болон **алдарт кофены үйлвэрээр** зочилно. Үргэлжлүүлэн **Граду палас** орж **Кесак бүжгийн үзүүлбэрийг** үзнэ. Орой нь зочид буудалдаа байрлан амарна.

Өдөр 5. Бали - Хонг Конг/Инчеон - Улаанбаатар

Өглөөний цайгаа зочид буудалдаа ууна. Ингээд зочид буудлын өрөөгөө хүлээлгэж өгөөд чөлөөт цаг. Орой тогтсон цагт цуглан Бали арлын Денпасар олон улсын нисэх онгоцны буудал явна. Ингээд дамжин нислэгээр нисч Улаанбаатар хотын Чингис хаан олон улсын нисэх буудалд бууснаар энэ удаагийн аялал өндөрлөнө.

Аялалын зардалд багтсан

- Балид 4 одтой зочид буудлын энгийн өрөөнд нэг өрөөнд 2-оор байрлах зардал.
- Хөтөлбөрт заасан тооны хоол
- Хөтөлбөрт заасан үзвэр, үйлчилгээ
- Жуулчны автобусны үйлчилгээ
- Гадаадад зорчигчдын иж бүрэн даатгал
- Орон нутгийн хөтөч
- Монгол хэлтэй ахлагч

Аялалын зардалд багтаагүй

- УБ - Бали- УБ ирж очих дамжин нислэгийн тийз /ойролцоогоор 1900.000 төгрөг/
- “Аяллын зардалд багтсан”-аас бусад зардал
- Хувь хүний хэрэглээний зардал
- Хөтөч болон жолооч-н гарын мөнгө